

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
УДИРТГАЛ.....	4

НЭГ. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1. Хууль зүйн туслалцааны төвөөс үйлчилгээ авсан иргэн, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үнэлгээ	7
1.2.Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд өгсөн хамтын ажиллагаа бүхий байгууллагын үнэлгээ	14
1.3.Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд өгсөн албан хаагчдын үнэлгээ	18

ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байдал	24
2.2. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан байдал	29
2.3. Хууль зүйн туслалцааны төвийн гадаад, дотоод хамтын ажиллагаа	33

ГУРАВ. УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. Улсын өмгөөлөгчийн ажиллах орчин нөхцөл	38
3.2. Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал	41
3.3. Улсын өмгөөлөгчийн мэргэшүүлэх, чадавхжуулах сургалт	44
ДҮГНЭЛТ	48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШУҮИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МӨХ	Монголын Өмгөөлөгчдийн холбоо
МҮОНРТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
МХХ	Монголын Хуульчдын холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗТТ	Хууль зүйн туслалцааны төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
IDLO	International Development Law Organization
ILF	International Legal Foundation

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн байршил
- График 2. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн насны байдал
- График 3. Хууль зүйн туслалцааны төвөөс үйлчилгээ авсан давтамж
- График 4. Хууль зүйн зөвлөгөө авсан хэлбэр
- График 5. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийг олж авсан эх сурвалж
- График 6. Хууль зүйн туслалцааны төвийн цахим хуудсанд зочилж байсан эсэх
- График 7. Хэрэв "Тийм" бол хэрэгтэй мэдээллээ авч чадсан уу?
- График 8. Хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг үнэлж буй байдал
- График 9. Хууль зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байсан эсэх
- График 10. ХЗТТ-өөр үйлчилгээний чанар, хүртээмж түргэн шуурхай байдлын үнэлгээ
- График 11. Үйлчилгээний орчин, нөхцөл, мэдээллийн ил тод байдалд өгч буй үнэлгээ
- График 12. ХЗТТ-ийн албан хаагчдын харилцаа хандлагын байдлын үнэлгээ
- График 13. Цаашид анхаарах шаардлагатай санал
- График 14. Танд өмгөөлөгчдийн зүгээс дараах хууль бус үйл ажиллагаа, дарамт шахалт үзүүлж байсан эсэх
- График 15. Улсын өмгөөлөгч таны санаа бодол, санал хүсэлтийг сонсож, анхаарч ханддаг эсэх
- График 16. Улсын өмгөөлөгч таны эрхийг хамгаалж чадсан эсэх
- График 17. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны үнэлгээ
- График 18. Судалгаанд оролцогчдын байршил, эрхэлж буй ажил
- График 19. Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллаж байсан туршлага бий эсэх
- График 20. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх байдал
- График 21. ХЗТТ-ийн үйл ажиллагааг олон нийгэд сурталчлах ажиллагаа
- График 22. Тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн ХЗТТ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг үнэлж буй байдал
- График 23. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг дүгнэж буй байдал
- График 24. Улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын талаарх байр суурь

- График 25. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээнд өгч буй үнэлгээ
- График 26. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний орчин нөхцөлийн үнэлгээ
- График 27. Ажиллах орчин нөхцөлдөө сэтгэл ханамжтай байдаг эсэх
- График 28. Улсын өмгөөлөгч үйл ажиллагаа явуулахад тулгарч буй гол бэрхшээл
- График 29. Өөрийн хийж байгаа ажилдаа тохирохуйц цалин хөлс авдаг эсэх
- График 30. Улсын өмгөөлөгч өөрийн ажлын ачааллаа үнэлсэн байдал
- График 31. Долоо хоногт ажлын шаардлагаар ажил дээрээ оройтох болон илүү цагаар ажилладаг давтамж
- График 32. Улсын өмгөөлөгчийн мэргэшсэн салбар эрх зүй
- График 33. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/ үйлчилсэн хугацаанаас хойш иргэний болон захиргааны хэрэгт ажилласан байдал
- График 34. Эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтанд хамрагдах хэрэгцээ шаардлага байгаа эсэх
- График 35. Хууль зүйн туслалцааны төвөөс явуулдаг улсын өмгөөлөгчийг чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийн үнэлгээ
- График 36. Хууль зүйн туслалцааны төвийн албан хаагчидтай харилцахад хүндрэл тулгардаг эсэх
- График 37. Байгууллагын соёл төлөвшсөн байдал
- График 38. Улсын өмгөөлөгчийн болон ажлын албаны үйл ажиллагааны үнэлгээ
- График 39. Хамт ажилладаг улсын өмгөөлөгчдийн мэргэжлийн ур чадварын үнэлгээ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Анкетын аргаар цуглуулах мэдээллийн түүврийн хэмжээ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Хууль зүйн туслалцааны төв
- Зураг 2. Хууль зүйн туслалцааны төвийн 6 салбарын ажлын байр шинэчилсэн байдал
- Зураг 3. ЕБС-д зохион байгуулсан сургалт
- Зураг 4. Улсын өмгөөлөгчийн мэргэшүүлэх, чадавхжуулах сургалт

УДИРТГАЛ

Монгол улс дэлхийн улс орнуудын нэгэн адил улсын хөгжлийн гол түлхүүр нь хүн байх ёстой гэдгийг нэгэнт хүлээн зөвшөөрч хөгжлийн түүхэн үйл явц, ололт амжилтаа дэнсэлж, судалгаанд үндэслэн “Алсын хараа 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогоо тодорхойлсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүрэгтэй” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж зааж өгсөн. Мөн Монгол Улс 1974 онд нэгдэн орсон НҮБ-ын “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “d”-д “... өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, ... өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх” гэж заасан. Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасны дагуу 2013 онд баталсан “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-иар зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах Хууль зүйн туслалцааны төвийг байгуулсан нь хүний эрх, эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хамгаалах үйл хэрэгт гаргасан нэг ахиц дэвшил төдийгүй хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулийн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн тогтолцооны шинэтгэлийн нэг байлаа.

Гэвч олон улсын туршлага, тухайн хуулийн хэрэгжилтийн явцад гарсан хуулийн үйлчлэлийн хүрээг өргөтгөн зохицуулах, эрх зүйн харилцаанд иргэн, захиргааны зарим хэрэг, маргаанд оролцогч төлбөрийн чадваргүй хүн, зарим зорилтот бүлгийн иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлагын улмаас Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2022 онд баталж, 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж, мөрдөж байна.

Монгол улсын хөгжлийн бодлогын гол цөм нь Монгол хүн байх бөгөөд Монгол хүний Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр хамгаалагдсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллага бол Хууль зүйн туслалцааны төв юм.

Хууль зүйн туслалцааны төв нь төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцааг мэргэжлийн түвшинд чанартай, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхэд хүний эрхийн байгууллагууд болон гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас туршлага судлах, улсын өмгөөлөгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшлүүлэх чиглэлийн сургалт хийх, үйл ажиллагаагаа сурталчлах, нийгэмд таниулах зэрэг бүхий л үйл ажиллагааны хүрээнд холбогдуулан “Эрх зүйн судалгааны төв” ТББ-аас Хууль зүйн туслалцааны төвийн хэрэглэгчийн үнэлгээг 3 бүлэгт хуваан судлан гүйцэтгэж, дүгнэлт зөвлөмж боловсруулсныг хүргэж байна.

Зорилго болон гарах үр дүн: Мониторингийн судалгааны зорилго нь Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үйлчилгээ авч буй төлбөрийн

чадваргүй үйлчлүүлэгчийн тухайлбал хэрэглэгчийн үнэлгээ, сэтгэл ханамж, хүлээлтийг тодорхойлж, тус үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжилтийг хангах, түүнд тулгарч буй сөрөг хүчин зүйлсийг даван туулахад чиглэсэн санал, зөвлөмж, нөлөөллийн саналыг боловсруулан гаргана.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- I. Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үйлчлүүлэгч, хамтран ажиллах байгууллагын албан хаагч, улсын өмгөөлөгч болон бусад албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин, үнэлгээг тодорхойлох, ингэхдээ үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээр гаргах;
- II. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэг, хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, түүний үр нөлөөг тодорхойлох;
- III. Үйл ажиллагааны талаарх олон нийтийн дэмжлэг, нийгэм сэтгэл зүйн таатай уур амьсгал бий болгож ажиллах чиглэлээр санал зөвлөмж, нөлөөллийн саналыг боловсруулах.

Хүлээгдэж буй үр дүн:

- 1) Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг тодорхойлох.
- 2) Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлд ач холбогдол бүхий дүгнэлт, зөвлөмж, нөлөөллийн санал боловсруулах.
- 3) Олон нийтэд судалгааны гол үр дүнгийн талаар хэлэлцүүлэг, танилцуулга хийгдэх боломжтой болно.

Мониторингийн аргачлал: Мониторингийн судалгаагаар тоон (анкет) болон чанарын (баримт бичгийн шинжилгээ) судалгааны загвар, арга зүйг хавсран хэрэглэнэ. Судалгааны зорилтуудад тусгасан үндсэн болон нарийвчилсан асуултад хэрхэн хариулт авахыг арга хэрэгсэл тус бүрээр доорх байдлаар харуулж байна.

Анкетын арга нь олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзэл, хандлага, үнэлгээг тодорхойлоход хамгийн тохиромжтой мэдээлэл цуглуулах үндсэн арга юм. Тиймээс энэхүү судалгаанд анкетын аргаар Хууль зүйн туслалцааны төвийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгч болон хамтын ажиллагаа бүхий Цагдаагийн ерөнхий газрын (цаашид ЦЕГ гэх), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын (цаашид ШШГЕГ гэх), Монголын хуульчдын холбооны (цаашид МХХ гэх), Хууль зүй, дотоод хэргийн яамны (цаашид ХЗДХЯ гэх), Засаг даргын тамгын даргын (цаашид ЗДТГ гэх) болон мөн шүүх байгууллагыг хамруулан мэдээлэл цуглуулна.

Судалгаанд нийт 3 төрлийн анкетын асуулга хэрэглэсэн. Үүнд:

- Үйлчилгээ авсан төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгчээс мэдээлэл цуглуулах анкет;
- Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс мэдээлэл цуглуулах анкет;
- Улсын өмгөөлөгч, албан хаагчдаас мэдээлэл цуглуулах анкет;

Анкетын судалгааны мэдээллийг PAPI буюу нүүр тулсан (Paper and Pen Interviewing) болон CAPI буюу цахим (Computer-assisted program interviewing) хэлбэрээр авахаар зохион байгуулав.

Баримт бичгийн шинжилгээний арга: Энэхүү судалгаанд холбогдох баримт бичгийг дараах ангилалд оруулан шинжилгээ хийхээр төлөвлөсөн болно. Үүнд:

- Хууль зүйн туслалцааны төвийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, тушаал, шийдвэр зэргийг агуулсан холбогдох баримт бичиг, тайлан, өргөдөл гомдолд шинжилгээ хийх;
- Судалгаанд холбогдох статистик, тоо, мэдээ, үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийх;

Хүснэгт 1. Анкетын аргаар цуглуулах мэдээллийн түүврийн хэмжээ

№	Мэдээлэл цуглуулсан субъект	Хэмжээ
1	Үйлчилгээ авсан төлбөрийн чадваргүй үйлдчлүүлэгчдээс мэдээлэл цуглуулах анкет	450
2	Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс мэдээлэл цуглуулах анкет	49
3	Албан хаагчдаас мэдээлэл цуглуулах анкет	54
4	Нийт	553

Мониторингийн хамрах хүрээ: Монгол улсын нийт нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Хууль зүйн туслалцааны төвийн 31 салбарыг хамарсан өргөн хүрээнд нэг удаагийн бус 4 сарын хугацаанд хууль зүйн туслалцаа, үйлчилгээ авсан үйлчлүүлэгч иргэдийг хамруулав.

Мөн хамтран ажиллаж байгаа цагдаа, прокурор, шүүхийн байгууллага, ХЗДХЯ, МХХ, МӨХ-ны төлөөлөл болох нийт 49 албан хаагчдыг энэхүү судалгаанд хамруулсан болно.

НЭГ. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Судалгааны энэ хэсэгт ХЗТТ-өөр үйлчлүүлэгчид болон хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл, төвийн нийт албан хаагчдаас авсан анкетын судалгааны үр дүнд үндэслэн ХЗТТ-ийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх юм.

Тус байгууллагаас үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийг хууль зүйн зөвлөгөө авсан иргэд болон өмгөөллийн үйлчилгээ авсан иргэд гэсэн хоёр үндсэн хэсэгт ангилан, ангилал тус бүрийн үр дүнг хооронд нь харьцуулан авч үзэх бол хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн эрхэлж буй ажил мэргэжлээр нь харьцуулан үр дүнг танилцуулах бөгөөд төвийн нийт албан хаагчдын анкетын судалгааг дүгнэн зөвлөмж хүргүүлэх юм.

1.1. Хууль зүйн тусалцааны төвөөс үйлчилгээ авсан иргэн, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үнэлгээ


Үйлчилгээ авсан иргэн, үйлчлүүлэгчээс цаас хэлбэрээр судалгааны мэдээллийг цуглуулсан бөгөөд нийт 450 иргэн, үйлчлүүлэгчийн мэдээллийг нэгтгэн үр дүнг танилцуулж байна.

График 1. Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгчийн байршил




Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 63 хувь нь орон нутгаас, 37 хувь нь нийслэлээс хамрагдсан байна.

График 2. Хууль зүйн тусалцааны төвөөс үйлчилгээ авсан иргэдийн насжилтийн байдал



Хууль зүйн тусалцааны төв нь 2023 онд нийт 16575 хүнд үйлчилгээ үзүүлсэн бөгөөд түүний 86 хувь нь 18-60 насны иргэн, 12 хувь нь насанд хүрээгүй иргэн, 2 хувь нь 60-аас дээш насны ахмад настан байна.

График 3. Хууль зүйн туслалцааны төвөөс үйлчилгээ авсан давтамж




Өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн 284 буюу 64.7 хувь нь анх удаа, 112 буюу 24.8 хувь нь 2-3 удаа, 47 буюу 10.4 хувь нь 3-аас дээш удаа өмгөөллийн үйлчилгээ авсан байна. Хууль зүйн зөвлөгөө авсан иргэдийн хувьд 284 буюу 57.2 хувь нь анх удаа, 137 буюу 27.6 хувь нь 2-3 удаа, 67 буюу 14.7 хувь нь 3 ба түүнээс дээш удаа зөвлөгөө авсан гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн хууль зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээ авсан судалгааг нэгтгэвэл дийлэнх 576 буюу 60.8 хувь нь анх удаа, 249 буюу 26.3 хувь нь 2-3 удаа, 122 буюу 12.9 хувь нь 3-аас дээш удаа үйлчилгээ авсан байгааг үзвэл хууль зүйн үйлчилгээ авах хүсэл сонирхол өндөр, тогтмол үйлчлүүлж байгааг харуулж байна.

График 4. Хууль зүйн зөвлөгөө авсан хэлбэр



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгч иргэдийн 374 буюу 82 хувь нь биечлэн, 16 буюу 3 хувь нь цахим хэлбэрээр, 67 буюу 15 хувь нь харилцаа холбооны хэрэгслээр үйлчилгээ авсан нь Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний боломжит бүх хэлбэрийг ашиглаж байгаа нь хүртээмж, хурдан, шуурхай байдал нэмэгдсэн байгааг илтгэж байна.

График 5. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийг олж авсан эх сурвалж



Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх буюу 68 хувь нь хувийн өмгөөлөгч, цагдаа, прокурор, шүүх болон бусад байгууллагаас ХЗТТ-ийн үйл ажиллагаа, үйлчилгээ, улсын

өмгөөлөгчийн талаар мэдээллийг авсан нь тус төвийн хамтын ажиллагаа бүхий байгууллагын албан хаагчдын мэдээлэл, цар хүрээ өргөжсөн байгааг харуулж байна. Мөн 28 хувь нь танил хүмүүс болон үйлчилгээ авч байсан иргэдээс мэдээлэл авсан байна. Энэ нь ХЗТТ-ийн үйлчилгээнд иргэд сэтгэл хангалуун байгааг харуулах үзүүлэлт юм. Түүнчлэн 4 хувь нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон нээлттэй хаалганы өдөрлөгөөс мэдээлэл авсан нь төвийн үйлчилгээг сурталчлах үйл ажиллагаа идэвхтэй, үр дүнтэй байгааг илтгэж байна.

График 6. Хууль зүйн туслалцааны төвийн цахим хуудсанд зочилж байсан эсэх






График 7. Тийм бол хэрэгтэй мэдээллээ авч чадсан эсэх




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 103 буюу 20 хувь нь ХЗТТ-ийн цахим хуудсанд зочилж байсан бөгөөд үүнээс 58 хувь нь өөрт хэрэгтэй мэдээллийг авч чадсан байна. 345 буюу 77 хувь нь үгүй гэж хариулсан нь иргэд холбогдох мэдээллийг албан ёсны цахим хуудсанд нэвтэрч, хайж олохоос илүүтэй танил хүнээсээ асуух, фейсбүүк, телевизээс мэдээлэл авах нь түгээмэл байна. Гэвч цахим хуудсан дахь мэдээллийг үйлчлүүлэгчид энгийн, ойлгомжтой хүргэх, хайсан мэдээллээ бүрэн авах боломжийг бүрдүүлэхэд анхаарч, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь ач холбогдолтой юм.

График 8. Хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг үнэлж буй байдал




Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь ХЗТТ-ийн хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд сэтгэл ханамж өндөр байна. Тухайлбал маш их сэтгэл ханамжтай үлдсэн үйлчлүүлэгч 258 буюу 53 хувь, сэтгэл ханамжтай үлдсэн нь 222 буюу 46 хувь байгаа бөгөөд дунд болон сэтгэл ханамжгүй үлдсэн үйлчлүүлэгч 1 хувь буюу маш цөөн хувийг эзэлж байна. Энэ нь тус төв нь үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын мэдлэг, ур чадвар, харилцаа, хандлагад анхаарч ажилласаны үр дүн гэж үзэж байна.

График 9. Хууль зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлэхэд хүндрэл тулгарч байсан эсэх




Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 98 хувь нь хууль зүйн туслалцаа, үйлчилгээ авахад хүндрэл, бэрхшээлгүй үйлчилгээ авсан нь дээрх үзүүлэлтээс харагдаж байна. Цөөн буюу 2 хувьд нь хүндрэл тулгарсан гэх бөгөөд үүнээс 6 хувь нь бичиг цаасны ажил ажил, байршил хол гэж, 13 хувь нь улсын өмгөөлөгчтэй уулзах, утсаар ярих боломж хязгаарлагдмал, хэлмэрч шаардлагатай байсан талаар дурдсан байна.

График 10. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдлын үнэлгээ




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 417 буюу 90.2 хувь нь ХЗТТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдалд сайн, 45 буюу 9.8 хувь нь дунд үнэлгээ өгсөн ба муу үнэлгээ огт өгөөгүй байгаа нь Төвийн үйл ажиллагаа иргэдэд түргэн, шуурхай, хүртээмжтэй хүрч үйлчилж байгааг харуулж байна.

График 11. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний орчин, нөхцөл, мэдээллийн ил тод байдлын үнэлгээ




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж хариу өгөх үнэлгээнд 99 хувь нь, санал шүүмж хүсэлт гаргах нөхцөл боломж нээлттэй байдалд 99 хувь, хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг авах боломжид 100 хувь нь, үйлчилгээний байрны тухтай байдалд 100 хувь нь сайн, дунд гэсэн үнэлгээ өгсөнийг нэгтгэн дүгнэвэл 409 буюу 90.5 хувь нь сайн, 60 буюу 9 хувь нь дунд, 4 буюу 0.5 хувь нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна. Иймд одоогийн үйлчилгээний чанрыг улам сайжруулахын тулд өмгөөлөгчийн орон тоог нь нэмэх, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулан тохижуулах, үйлчлүүлэгчтэй уулзах уулзалтын өрөөг бэлтгэх саналыг чанарын судалгааны явцад онцолж байв.

График 12. Хууль зүйн туслалцааны төвийн албан хаагчдын харилцаа хандлагын байдлын үнэлгээ




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдээс Төвийн албан хаагчдын харилцаа хандлагыг 284 буюу 60.5 хувь нь маш сайн, 179 буюу 38.2 хувь нь сайн, 9 буюу 1.9 хувь нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байна. Тус байгууллагын соёл, албан хаагчдын харилцаа хандлага зөв төлөвшиж байгааг харуулж байна.

График 13. Цаашид анхаарах шаардлагатай гэсэн санал, хүсэлт



Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдээс 107 буюу 80 хувь нь хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох гэж, 9 буюу 7 хувь нь асуудлыг шийдвэрлэх үе шат, хүнд суртал, чирэгдлийг бууруулах гэж, 5 буюу 3.75 хувь нь удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах гэж, 3 буюу 2.3 хувь нь ажилтаны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх гэж хариулсан байна.

График 14. Танд улсын өмгөөлөгчийн зүгээс дараах хууль бус үйл ажиллагаа, дарамт шахалт үзүүлж байсан эсэх




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 384 буюу 84.6 хувь нь улсын өмгөөлөгчийн зүгээс хууль бус үйл ажиллагаа, дарамт шахалт үзүүлээгүй гэж, 69 буюу 15.2 хувь нь төлбөр нэхэж байсан гэж, 1 буюу 0,2 хувь нь ашиг сонирхолын зөрчилтэй гэдгээ нуун дарагдуулсан гэж хариулсан байна. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохих зөвлөмж чиглэл хүргүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

График 15. Улсын өмгөөлөгч таны санаа бодол, санал хүсэлтийг сонсож, анхаарч хандсан эсэх




Улсын өмгөөлөгч үйлчлүүлэгчийн санаа, санал бодлыг сонсож, анхаарч үзсэн эсэхэд судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчийн 463 буюу 99.4 хувь нь анхаарч үзсэн гэж, 2 буюу 0.4 хувь нь хааяа гэж, 1 буюу 0.2 хувь нь огт сонсоогүй гэж хариулсан байна.

График 16. Таны хувьд улсын өмгөөлөгч таны эрхийг хамгаалж чадсан эсэх



Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчийн 449 буюу 99.8 хувь нь улсын өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалж чадсан гэж, 1 буюу 0.2 хувь нь хамгаалж чадаагүй гэж хариулсан байна.

График 17. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны үнэлгээ




Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчийн 473 буюу 100 хувь нь улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг сайн гэж хариулсан байна.

1.2. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд өгсөн хамтын ажиллагаа бүхий байгууллагын үнэлгээ


Хууль зүйн туслалцааны төвийн хамтын ажиллагаа бүхий байгууллагын 49 албан хаагчийг судалгаанд хамруулан нэгтгэн дүгнэв.

График 18. Судалгаанд оролцогчдын байршил, эрхэлж буй ажил



Нийт судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын албан хаагчдын 98 хувь нь нийслэлээс, 2 хувь нь орон нутгаас оролцсон бөгөөд 4 хувь нь ХЗДХЯ, 22 нь цагдаагийн мөрдөгч, 35 хувь нь шүүгчийн туслах, 4 хувь нь шийдвэр гүйцэтгэгч, 33 хувь нь прокурор, 2 хувь нь ЗДТГ-ыг албан хаагчид байв.

График 19. Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллаж байсан туршлагатай эсэх



Судалгаанд оролцсон хамтын ажиллагаа бүхий 6 байгууллагын 48 буюу 98 хувь нь нийслэлээс, 1 буюу 2 хувь нь орон нутгийн нийт 49 албан хаагчаас судалгааг авсан болно. Үүнээс 44 буюу 90 хувь нь төвтэй хамтран ажиллаж байсан, 5 буюу 10 хувь нь хамтран ажиллаж байгаагүй албан хаагчид судалгаанд хамрагдсан байна.

График 20. Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх байдал



Төвийн өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэж буй байдлыг нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдаас 36 буюу 73.5 хувь сайн, 6 буюу 12 хувь нь дунд, 7 буюу 14 хувь нь мэдэхгүй гэж, муу гэж хариулсан хариулт өгөөгүй байна.


Төвийн удирдлагын зүгээс тус байгууллагад ирсэн өргөдөл, гомдолын шийдвэрлэлт хугацаа хэтэрсэн тохиолдол байхгүй бөгөөд хариутай албан бичгийн эргэлт 1-3 хоногт хариуг өгч шийдвэрлэх жишиг нэгэнт тогтсон тухай ярилцлагын үед тэмдэглэж байсан. Үүнийг төвийн холбогдох бичиг баримтын бүртгэл болон архиваас үзэхэд нотлогдож байсныг онцолж байна.

График 21. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажиллагаа



Судалгаанд оролцогчдоос төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажиллагааг 23 буюу 47 хувь нь сайн, 6 буюу 12 хувь нь дунд, 3 буюу 6 хувь нь муу, 5 буюу 10 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Төвийн үйл ажиллагааг хамтын ажиллагаатай төрийн болон төрийн бус байгууллагуудад танилцуулах нь үр дүнг нэмэгдүүлэх юм.


График 22. Тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн ХЗТГ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг үнэлж буй байдал



Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдаас үйлчлүүлэгчийн хууль зүйн туслалцааны төвийн талаарх мэдээлэлтэй байгаа эсэхэд ЗДТГ, ШШГЕГ-ын албан хаагчид 100 хувь сайн, прокурорын 50 хувь нь сайн, 44 хувь нь муу, 6 хувь нь буруу ойлголттой, шүүхийн 47 хувь нь сайн, 47 хувь нь муу, 6 хувь нь буруу ойлголттой, цагдаагийн мөрдөгчийн 73 хувь нь сайн, 27


хувь нь муу гэж хариулсан байна. Дүгнэж үзвэл судалгаанд оролцогчдын 57 хувь нь сайн, 38 хувь нь муу, 4 хувь нь буруу ойлголттой байсан байна.

График 23. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ




Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын албан хаагчдын 40 буюу 81.6 хувь нь улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд талархалтай ханддаг гэж, 3 буюу 6 хувь нь үйлчилгээнд эргэлзээтэй ханддаг гэж хариулсан байна.

График 24. Улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын талаарх таны байр суурь



Судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын албан хаагчид нь улсын өмгөөлөгчийн ажлын ачааллыг 28 буюу 57.1 хувь нь их, 1 буюу 2 хувь нь бага, 11 буюу 22.4 хувь нь боломжийн, 9 буюу 18.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

График 25. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээнд өгч буй үнэлгээ



Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээнд өгч буй үнэлгээгээр үйлчилгээг хуулийн хугацаанд шуурхай үзүүлэх байдалд 39 буюу 80 хувь нь сайн, 6 буюу 12.2 хувь нь дунд, 4 буюу 8 хувь нь мэдэхгүй гэх, тэгш ялгаваргүй үзүүлэх байдалд 41 буюу 84 хувь нь сайн, 5 буюу 10.2 хувь нь дунд, 3 буюу 6.1 хувь нь мэдэхгүй гэж, үйлчилгээний чанар, үр дүнг 40 буюу 82 хувь нь сайн, 5 буюу 10.2 хувь нь дунд, 4 буюу 8 хувь нь мэдэхгүй гэж, улсын өмгөөлөгчийн зан харилцаа, ёс зүйг 45 буюу 92 хувь нь сайн, 3 буюу 6.1 хувь нь мэдэхгүй гэж, 1 буюу 2 хувь нь дунд, муу гэж, улсын өмгөөлөгчийн туршлагатай байдалд 43 буюу 88 хувь нь сайн, 2 буюу 4 хувь нь дунд, 4 буюу 8 хувь нь мэдэхгүй гэж, улсын өмгөөлөгчийн мэргэжлийн ур чадвар 43 буюу 88 хувь нь сайн, 3 буюу 6.1 хувь нь дунд, 3 буюу 6.1 хувь нь мэдэхгүй гэж, өмгөөллийн үйл ажиллагааны талаар хариу мэдээлэдэг, эргэж холбогддог байдалд 41 буюу 84 хувь нь сайн, 5 буюу 10.2 хувь нь дунд, 3 буюу 6.1 хувь нь мэдэхгүй гэж, өмгөөлөгч үйлчилгээний талаар хангалттай мэдээлэл өгөх байдалд 41 буюу 84 хувь нь сайн, 4 буюу 8 хувь нь дунд, 4 буюу 8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Дээрх үзүүлэлтийг нэгтгэж дүгнэвэл, ХЗТТ-ийн үйлчилгээг 85.2 хувь нь сайн, 7.8 хувь нь дунд, 7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

График 26. Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний орчин нөхцөлийн үнэлгээ



Хамтын ажиллагаатай байгууллагын албан хаагчдаас гаргасан санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж хариу өгөх арга хэмжээ авах гэдэгт 41 буюу 84 хувь нь сайн, 3 буюу 6.1 хувь нь дунд, 5 буюу 10.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байх бөгөөд муу гэж хариулсан хариулт байхгүй байна.

Үйлчилгээний өрөө танхимын нөхцөл, ая тухтай байдал 45 хувь нь сайн, 14 хувь нь дунд, 10 хувь нь муу, 31 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Мэдээллийг өөр хэлбэрээр авах боломж 53 хувь нь сайн, 27 хувь нь дунд, 4 хувь нь муу, 16 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Нэгтгэж дүгнэвэл, Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний орчин нөхцөлийн үнэлгээ 76.7 хувь нь сайн, 4.3 хувь нь муу, 19 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

1.3. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд өгсөн албан хаагчдын үнэлгээ


Хууль зүйн туслалцааны төвийн нийт 54 албан хаагчийг (улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслах болон ажлын албаны албан хаагч) судалгаанд хамруулан нэгтгэн дүгнэлт хийж байна.

График 27. Ажиллах орчин нөхцөлдөө сэтгэл ханамжтай байдаг эсэх



Судалгаанд хамрагдсан 54 албан хаагчдаас ажиллах орчин нөхцөлдөө сэтгэл ханамжтай байдалд 61.1 хувь нь сэтгэл хангалуун, 35.2 хувь нь дунд, 3.7 хувь нь сэтгэл хангалуун бус гэж хариулсан байна.

График 28. Улсын өмгөөлөгч үйл ажиллагаа явуулахад тулгарч буй гол бэрхшээл




Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээл гэдэгт 44.4 хувь нь материаллаг орчин нөхцөл тааруу гэж, 7.4 хувь нь үйлчлүүлэгчийн харилцаа хандлага муу, 1.9 хувь нь үйлчлүүлэгчтэй харилцахад бэрхшээл учирдаг гэж, мөн хөгжих боломж бага гэж, 13 хувь нь цалин хөлс бага гэж, 27.8 хувь нь бэрхшээл байхгүй гэж хариулсан байна. Байгууллагын зүгээс шийдвэрлэх боломжтой асуудлыг шийдвэрлэхэд анхаарах нь зүйтэй.

График 29. Авч буй цалиндаа сэтгэл хангалуун байдаг эсэх




Төвийн албан хаагчид авч буй цалиндаа 37 хувь нь сэтгэл хангалуун, 55.6 хувь нь сэтгэл дундуур, 7.4 хувь нь хангалтгүй гэж хариулсан байна. Цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлээд 1 жилийн хугацаа болж байгаа энэ үед ийм хариулт гарч байгаа нь эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж дүгнэлт хийх нь илүү оновчтой юм.

График 30. Улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын талаарх үнэлгээ




Төвийн албан хаагчдаас улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын талаар 57.4 хувь нь хэвийн, 42.6 хувь нь их гэж хариулсан нь бодит байдалтай нийцэж байна.

График 31. Долоо хоногт ажлын шаардлагаар илүү цагаар ажиллах шаардлага гардаг эсэх




Төвийн албан хаагчдын 7 хоногт илүү цагаар ажиллах шаардлага гардаг эсэхэд 9 хувь нь 4 ба түүнээс дээш удаа, 43 хувь нь 2-3 удаа, 19 хувь нь 1 удаа, 28 хувь нь амралтын өдрүүдээр гэж хариулсан нь улсын өмгөөлөгч, албан хаагчид ажлын ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна.

График 32. Улсын өмгөөлөгчийн мэргэшсэн салбар эрх зүй




Судалгаанд хамрагдсан улсын өмөөлөгчдийн 81.5 хувь нь эрүүгийн эрх зүй, 11.5 хувь нь иргэний эрх зүй, 1.9 хувь нь захиргааны эрх зүй гэж хариулсан байна. Энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой байх бөгөөд бусад салбар эрх зүйгээр мэргэшүүлэх, тэнцвэржүүлэхэд анхаарах шаардлагатай.

График 33. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн үйлчилсэн хугацаанаас хойш иргэний болон захиргааны хэрэгт ажилласан эсэх




Улсын өмгөөлөгчид иргэн, захиргааны хэрэг маргаанд 45.3 хувь нь ажилласан бол, 54.7 хувь нь оролцоогүй байна.

График 34. Эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтанд хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх




Улсын өмгөөлөгчид эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтанд хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхэд 46.3 хувь маш их, 44.4 хувь нь их, 9.3 хувь дунд зэрэг гэж хариулсан байна.

График 35. Хууль зүйн туслалцааны төвөөс явуулдаг улсын өмгөөлөгчийг чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийн үнэлгээ




Хууль зүйн туслалцааны төвөөс явуулдаг улсын өмгөөлөгчийг чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийн үнэлгээг 30.8 хувь маш сайн, 63.5 хувь нь сайн, 5.8 хувь дунд зэрэг гэж хариулсан байна. Тус төвөөс явуулсан сургалтын чанар, үр өгөөж өндөр байгааг харуулж байна.

График 36. Байгууллагын албан хаагч нартай харилцахад хүндрэл тулгардаг эсэх




Төвийн албан хаагчдын хоорондын харилцаанд 92.6 хувь нь ямар нэг хүндрэл гардаггүй гэж, 7.4 хувь тийм гэж хариулсан байна. Байгууллагын дотоод уур амьсгал хэвийн гэж дүгнэж байна.

График 37. Байгууллагын соёлын төлөвшсөн байдал




Байгууллагын соёл төвшин тогтсон байдалд 18.9 хувь нь зөв соёл тогтсон гэж, 64.2 хувь нь зөв соёл, хандлага төлөвшиж байгаа гэж, 15.1 хувь нь мэдэхгүй гэж, 1.9 хувь нь буруу хандлага тогтсон гэж дүгнэсэн байна. Төв нь 2023 онд байгууллагын зөв соёл тогтоох зорилт дэвшүүлсэн байх бөгөөд энэхүү зорилтоо хангаж чадсан байна.

График 38. Удирдлагын болон ажлын албаны үйл ажиллагааны үнэлгээ



Төвийн ажлын албаны үйл ажиллагааг 92.5 хувь маш сайн, сайн, 7.5 хувь нь дунд гэж үнэлсэн байна. Удирдлагын үйл ажиллагааг 96.3 хувь нь маш сайн, сайн, 3.7 хувь дунд гэж үнэлсэн байна.

График 39. Хамт ажилладаг бусад улсын өмгөөлөгчдийн мэргэжлийн ур чадварын үнэлгээ



Улсын өмгөөлөгчид бусад улсын өмгөөлөгчдийн мэргэжлийн ур чадварыг 59.3 хувь нь маш сайн, 40.7 хувь нь сайн гэж үнэлсэн байна.

ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байдал

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоох зорилтын хүрээнд Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг батлан, 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж хуульчилсан.

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга), дүрэм журмын хэрэгжилтийг хангах хүрээнд тус хуулийг дагаж гарах дүрэм, журмыг боловсруулах, батлан гаргах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан болон холбогдох мэдээлэлд үндэслэн үнэлгээ хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/71 тоот тушаалаар Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдөр хуралдан Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж гарах дүрэм журмыг боловсруулах ажлын хүрээнд хэм хэмжээ тогтоосон журмын төлөвлөгөөг өөрчлөн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж батлуулсан төлөвлөгөөний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/343 тоот тушаалаар “Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-ний загвар, “Хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээ”-ний загвар, “Өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээ”-ний загвар, “Хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэр”-ийн загварыг тус тус батлуулжээ.

Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж гарах нийт 19 дүрэм журмын төслийг боловсруулан 17 журмыг батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

I. Засгийн газрын тогтоолоор “Улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”, “Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын удирдах, гүйцэтгэх болон туслах албан тушаал, улсын өмгөөлөгчийн туслахын албан тушаалын ангилал, зэрэглэл”, “Аймгийн төв, аймгийн төвөөс бусад сум, алслагдсан дүүрэгт ажиллаж байгаа улсын өмгөөлөгчид мөнгөн урамшуулал олгох журам” батлагдсан:

II. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Хууль зүйн туслалцааны төвийн бүтэц, орон тоо”, “Хууль зүйн туслалцааны төвийн дүрэм” “Улсын өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй болон хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээний загвар, хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах

шийдвэрийн загвар” “Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, “Улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах журам”, “Хууль зүйн туслалцаа үзүүлэх хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн хөлсний жишиг”, “Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Улсын өмгөөлөгчийн цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс”, “Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хамгаалах, мэдээлэл солилцох журам”, “Улсын өмгөөлөгч болон улсын өмгөөлөгчийн туслахад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт” батлагдсан.

III. Хууль зүйн туслалцааны төвийн захирлын тушаалаар “Хууль зүйн туслалцаа хүсэх өргөдлийн загвар”, “Өмгөөллийн үйлчилгээний хувийн хэрэг бүрдүүлэх, тайлагнах журам”, “Өмгөөллийн үйлчилгээний тайлангийн загвар” батлагдсан:

IV. Төслийг боловсруулж батлах эрх бүхий байгууллагад “Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ыг Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд, “Хууль зүйн туслалцаа үзүүлэх орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ын боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад батлуулах хүсэлтийн хамт хүргүүлсэн байна.

2023 онд шинээр батлагдан хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхэлсэн бусад хууль тогтоомжийг биелүүлэх, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж дагаж мөрдсөнтэй холбогдуулан Төвийн төрийн үйлчилгээний албан хаагчидтай байгуулах “Хөдөлмөрийн гэрээ” болон “Хөлсөөр ажиллах гэрээ”-г шинэчлэн боловсруулж, үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээг дахин байгуулж, баталгаажуулсан.

2. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) дагаж мөрдөж эхэлсэн, Хууль зүйн туслалцааны тухай тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2023 оны А/24 дугаар тушаалаар Төвийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ийн шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байдал: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж заасан. Мөн 1995 онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг баталсан нь өргөдөл гомдол гаргагчийн эрх, түүнийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн.

Хууль зүйн туслалцааны төвд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж, тодорхой арга хэмжээ авч ажилладаг.

Хууль зүйн туслалцааны төв 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийн хүрээнд 2850 эрүүгийн хэрэгт холбогдсон 2736 холбогдогч /сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан/-д, эрүүгийн хэргийн 83 хохирогч, 10 гэрчид, захиргааны хэргийн 5 оролцогчид, иргэний хэргийн 55 нэхэмжлэгчид, зөрчлийн

хэргийн 74 оролцогчид өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн. Хууль зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд 2023 онд нийт 10778 хүнд иргэний эрх зүйн маргаантай зөвлөгөө мэдээллийг 1753, эрүүгийн эрх зүйн маргаантай 8551, зөрчлийн хэргийн маргаантай холбоотой 299, захиргааны эрх зүйн маргаантай холбоотой 175 хүнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн 2835 хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулж ажилласан байна.

Төвийн ажлын албанд хүний нөөцийн асуудалтай холбоотой 144, улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой 23, хууль зүйн туслалцаа хүссэн 406, төрийн болон бусад байгууллагаас ирүүлсэн 153 хариутай албан бичиг, 101 хариугүй албан бичиг хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж хариу өгчээ.

График 20. Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх байдал



Харин хамтын ажиллагаа бүхий байгууллагын судалгаанд хамрагдсан албан хаагчдаас Төвийн өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэж буй байдлыг дүгнэсэн байдлыг авч үзвэл 36 буюу 73.5 хувь сайн, 6 буюу 12 хувь нь дунд, 7 буюу 14 хувь нь мэдэхгүй гэж, муу гэж хариулсан хариулт өгөөгүй байна.

Төвийн удирдлагын зүгээс тус байгууллагад ирсэн өргөдөл, гомдолын шийдвэрлэлт хугацаа хэтэрсэн тохиолдол байхгүй бөгөөд хариутай албан бичгийн эргэлт 1-3 хоногт хариуг өгч шийдвэрлэх жишиг нэгэнт тогтсон тухай ярилцлагын үед тэмдэглэж байсан. Үүнийг Төвийн холбогдох ирсэн, явсан бичиг баримтын бүртгэл болон ирсэн явсан бичиг хэргийн архиваас үзэхэд нотлогдож байсныг онцолж байна.

Улсын өмгөөлөгчийн эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил: Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 5 дугаар зүйлийн 5.1.3-т эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлыг хууль зүйн туслалцааны төрөлд оруулан хуульчилсан нь Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилт 3-т Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна. Мөн зорилтын 3.3.2-т эрх зүйн болон хүний эрхийн сургалт, сурталчилгаанд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбар болон бусад холбогдох этгээдийн оролцоог нэмэгдүүлэх гэж, Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв. Засаглалын бодлого, 4.4.9-т Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр

хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.5-ын хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн, I үе шат (2021-2030): Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх гэж үечлэн хууль тогтоомжид тусгасныг хууль зүйн туслалцааны төв хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн талаараа тайландаа дурджээ.

Тус төвөөс эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. МХХ, МӨХ, аймаг нийслэлийн ЗДТГ-тай хамтран 15 удаагийн өдөрлөг зохион байгуулан оролцож нийслэл, орон нутгийн 392 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

2. Нийслэл, орон нутгийн политехникийн коллеж, ерөнхий боловсролын 109 сургуулийн ахлах ангийн 9763 сурагч хүүхдүүдэд зориулан “Эрх зүйн мэдлэг олгох” сургалт зохион байгуулсан.

3. Улаанбаатар их сургуулийн эрх зүйн ангийн 3, 4 дүгээр курсийн 40 оюутнуудад Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, хуулийн шинэчилсэн найруулгын талаар танилцуулан, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, анхаарах асуудлууд сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.

4. Хууль зүйн туслалцааг аль болох эрт үзүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд тус төвөөс гадагшаа чиглэсэн 12 удаагийн сургалтаар 308 иргэнд зөвлөгөөний арга хэмжээ зохион байгуулсан.

5. Хууль зүйн туслалцааны тухай хууль, төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах 18 постер бэлтгэн веб сайт, фэйсбүүк, твитерт байршуулсан.

6. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн бэлтгэдэг “1800-1202” подкастын 9 дугаарт чиг үүрэгт хамаарах сэдвээр ярилцлага өгч орсон.

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дэмжлэгээр Eagle телевизийн “Сэргийлэгч” зорилтот нэвтрүүлгийн 1 удаагийн дугаарт “Хууль зүйн туслалцааны тухай хууль” сэдвээр нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

8. Хууль зүйн туслалцааны тухай хууль болон Төвийн үйл ажиллагааны талаар 1 видео ажилбар бэлтгэн веб сайт, фэйсбүүк, твитерт байршуулан олон нийтэд хүргэсэн.

9. Хууль сурталчлах чиглэлээр телевизийн болон радио нэвтрүүлэгт оролцож нийт 13 удаагийн ярилцлага өгсөн.

10. Мэдээллийн сайтад 5 удаагийн ярилцлага өгсөн.

Дээр дурдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахад Хууль зүйн туслалцааны төв хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлэхдээ төрийн бусад байгууллагын хуульд заасан нийтлэг чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, түүнчлэн энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгааг судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгчид илэрхийлсэн байна. Тус арга хэмжээг хамтын ажиллагааны хүрээнд ямар нэг зардал, төсөвгүй зохион байгуулсан байгааг сайшааж байна.

График 21. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажиллагаа



Харин хамтын ажиллагаа бүхий байгууллагын судалгаанд хамрагдсан албан хаагчдаас төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажиллагааг 23 буюу 47 хувь нь сайн, 6 буюу 12 хувь нь дунд, 3 буюу 6 хувь нь муу, 5 буюу 10 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Төвийн үйл ажиллагааг хамтын ажиллагаатай төрийн болон төрийн бус байгууллагуудад танилцуулах нь үр дүнг нэмэгдүүлэх боломжтой юм.

2.2. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан байдал

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлийн 11.1.10-т Туслалцааны төв нь хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг нийтэд сурталчлах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

Хууль зүйн туслалцааны төв нь 2023 онд хууль тогтоомж, байгууллагын чиг үүргийг сурталчлах ажлыг зохион байгуулах үндсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд үүний зэрэгцээ байгууллагаа таниулан сурталчлах зорилгоор иргэдтэй мэдээлэл солилцох урсгалыг хурдасгах, хуульд заасан нээлттэй мэдээллийг ил болгож цахим хуудаст тогтмол байршуулах, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлан, холбогдох мэдээллийг ил тод болгох зэрэг ажлуудыг төлөвлөсөн байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийг сурталчлах хүрээнд видео шторк, дохионы хэлтэй мэдээ видео, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг агуулсан постерууд, инфографик байдлаар хийсэн видео контент зэргийг ТВ8, UBS, МҮОНРТ, Ийгл ТВ, Боловсрол суваг телевизүүдэд сурталчлах, 1 видео ажилбар, 18 постер бэлтгэн веб сайт, фэйсбүүк, твитер, цахим хуудсаар олон нийтэд түгээжээ. Мөн дараах сургалт зохион байгуулах хэлбэрээр хэрэгжүүлсэнийг онцлон тэмдэглэж байна. Үүнд:

1. Нийслэл, орон нутгийн политехникийн коллеж, ерөнхий боловсролын 109 сургуулийн ахлах ангийн 9763 сурагч хүүхдүүдэд зориулан “Эрх зүйн мэдлэг олгох” сургалт
2. Улаанбаатар их сургуулийн эрх зүйн ангийн 3, 4 дүгээр курсийн 40 оюутнуудад Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, хуулийн шинэчилсэн найруулгын талаар танилцуулан, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, анхаарах асуудлууд сэдвийн хүрээнд сургалт
3. Хууль зүйн туслалцааг аль болох эрт үзүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд тус төвөөс гадагшаа чиглэсэн 12 удаагийн сургалтаар 308 иргэнд зөвлөгөө өгөх арга хэмжээ зохион байгуулсан.

Түүнчлэн иргэд хууль зүйн туслалцаа авах хүсэлтийг И-Монголиа системээр дамжуулан ирүүлэх нөхцөл боломж бүрдсэн талаарх мэдээлэл бүхий хоёр постер, иргэдэд зориулсан зарим заавар зэргийг байгууллагын фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэсэн байна. Мөн Монголын Үндэсний олон нийтийн радио телевизээс бэлтгэн хүргэдэг “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож, Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, хууль зүйн туслалцааг хэрхэн авах, улсын өмгөөлөгчийн ажлын нэг өдрийг харуулсан контентыг бэлтгэх ажлыг зохион байгуулжээ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн бэлтгэдэг 1800-1202 подкастын 9-н дугаарт ярилцлага өгөн оролцож, МХХ, МӨХ, аймаг нийслэлийн ЗДТГ-тай хамтран 15 удаагийн өдөрлөг зохион байгуулан оролцож нийслэл, орон нутгийн 392 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэд, олон нийтэд Хууль зүйн туслалцааны тухай хууль, Төвийн үйл ажиллагааны талаар сурталчилж, мэдээлэл өгч, брошур тараах ажлуудыг гүйцэтгэжээ.


Тус байгууллагаас судалгааны багт хүргүүлсэн мэдээллийг дүгнэж үзэхэд ХЗТТ-өөс 2023 онд хууль зүйн туслалцааны тухай хууль тогтоомж болон байгууллагаа сурталчлах чиглэлээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дэмжлэгээр Eagle телевизийн “Сэргийлэгч” зорилтот нэвтрүүлгийн 1 удаагийн дугаарт “Хууль зүйн туслалцааны тухай

хууль” сэдвээр нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн зэрэг нийт 13 телевизийн болон радио нэвтрүүлэг, мэдээллийн сайтад 6 удаагийн ярилцлага, 9 подкастад оролцсон, цөөнгүй тооны постер хийлгэж тэдгээрийг ашиглан уралдаанд оролцсон, эдгээр постерууд болон холбогдох танилцуулга, мэдээллүүдийг төвийн албан ёсны цахим сайт, фейсбүүк пэйжээр олон нийтэд түгээх, бусад байгууллагуудтай хамтран нийслэлийн болон орон нутгийн Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсийн дарга нар, иргэд, олон нийтэд биечлэн мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Иргэн хууль зүйн туслалцаа хүссэн өргөдлийг цахимаар ирүүлж шийдвэрлүүлэх боломж бүрдсэн бөгөөд хууль зүйн туслалцааны мэдээллийн нэгдсэн сан дахь И-Монголиа системээр дамжуулан 2023 оны байдлаар хууль зүйн туслалцаа хүссэн 336 өргөдлийг хүлээн авч байгаа шийдвэрлэн хууль зүйн туслалцаа үзүүлсэн нь сайшаалтай байна.

Эдгээрээс гадна нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг ил болгож цахим хуудаст тогтмол байршуулах, хуульд заасан холбогдох мэдээллийг ил болгож, цахим хуудаст байршуулах, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагууд болон Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбооны цахим сайт, телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн байгууллагуудтай хамтран нийтэд хүргэжээ.

График 5. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийг олж авсан эх сурвалж



Өөрөөр хэлбэл өмнө нь ХЗТТ-өөс үйлчилгээ авсан иргэд тус байгууллагын үйлчилгээг бусад шаардлагатай иргэдэд хүргэж буй мэдээллийн эх үүсвэр болж байна. Мөн үйлчилгээ авсан иргэд улсын өмгөөлөгчдийн үйлчилгээг бусдад санал болгож буй буюу үйлчилгээнд сэтгэл хангалуун үлдсэнийг харуулах үзүүлэлт гэж үзэж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгч иргэдийн 20 хувь нь ХЗТТ-ийн цахим хуудсанд зочилж байсан туршлагатай байв. Энэ нь өмнөх жилийнхээс 15.6%-аар өссөн байна. Харин цахим хуудсанд зочилсноор хэрэгтэй мэдээллээ олж авч чадсан эсэхийг тодруулахад 58 хувь нь тийм гэж хариулсан нь өмнөх жилээс 25.6%-аар өссөн байна. Цахим хуудсанд нэвтэрч үзээгүй хувь 77 гаруй хувь байгаа байгаа нь өмнөх оноос 17 хувь буурсан байгаа нь сайшаалтай байна. Цаашид цахим хуудсыг сурталчлан таниулах, цахим хуудасны мэдээллийг иргэн, үйлчлүүлэгчдэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр байршуулах, түгээмэл асуулт, хариултын буланг хөгжүүлэх замаар цахим хуудаст зочилсон үйлчлүүлэгч бүр эрж, хайсан мэдээллээ олж авах боломжийг цаашид бүрдүүлэх шаардлагатай байна.

График 6. Хууль зүйн туслалцааны төвийн цахим хуудсанд зочилж байсан эсэх





График 7. Тийм бол хэрэгтэй мэдээллээ авч чадсан эсэх



Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар хамтран ажиллагч байгууллагууд мэдээлэл авсан эсэхийг тодруулж үзэхэд судалгаанд хамрагдсан хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллийн 66 хувь нь Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл авсан байна. Энэ нь өмнөх оноос 15 хувиар өссөн байна. Харин хамтран ажиллагч байгууллагуудын төлөөллөөс 78 хувь нь хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажил сайн, дунд гэж үнэлсэн нь өмнөх жилээс 24.7 хувиар өссөн байна. Үүний зэрэгцээ хамтын ажиллагаа бүхий бусад байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн хувьд 71.5 хувь болж нэмэгдсэн нь өмнөх жилээс 44.1 хувиар өссөн байна. ХЗТТ-ийн талаар мэдлэг, мэдээлэл сайтай байгаа бол 26 хувь нь мэдээлэл муу, 3 хувь нь буруу ташаа ойлголттой болсон нь өмнөх оноос 1.2 хувь буурсан байгааг доорх графикаас харж болохоор байна.

График 21. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажиллагаа



Эдгээрийг дүгнэж үзвэл ХЗТТ нь Хууль зүйн туслалцааны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэд, олон нийт, байгууллагуудад хууль тогтоомж, байгууллагын чиг үүргийг сурталчлахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх буюу 68 хувь нь өмгөөлөгч, цагдаа, прокурор, шүүх болон бусад байгууллагаас дамжуулан ХЗТТ-ийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн үйлчилгээний талаар мэдээллийг авсан нь тус төвийн хамтын ажиллагаа бүхий байгууллагын мэдээлэл, цар хүрээ өргөжсөн байгааг харуулж байна. Мөн 28 хувь нь танил хүмүүс болон үйлчилгээ авч байсан иргэдээс мэдээлэл авсан байна. Энэ нь ХЗТТ-ийн үйлчилгээнд иргэд сэтгэл хангалуун байгааг харуулах үзүүлэлт юм. Түүнчлэн 4 хувь нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон нээлттэй хаалганы өдөрлөгөөс мэдээлэл авсан нь төвийн үйлчилгээг сурталчлах үйл ажиллагаа идэвхтэй, үр дүнтэй байгааг илтгэж байна.

2.3. Хууль зүйн туслалцааны төвийн гадаад, дотоод хамтын ажиллагаа

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлийн 11.1.9-т ХЗТТ нь чиг үүргийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр, тус зүйлийн 11.1.4-т улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, 11.1.5-т салбар байгуулагдаагүй нутаг дэвсгэрт хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах, 11.1.11-т эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах гэж гадаад дотоод хамтын ажиллагааг хэрэгжүүлэх хүрээг нь тодорхой зааж өгсөн байна.

Хууль зүйн туслалцааны төв нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх гэсэн үндсэн зорилтуудыг тусгаснаас гадна байгууллагын мэдээллийн нэгдсэн санд суурилсан программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх, улсын өмгөөлөгчийг хуульчийн багц цаг цагийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах гэсэн ажлуудыг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр: ХЗТТ нь 2023 онд гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран улсын өмгөөлөгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 1-2 удаагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байсан байна. Гэвч тухайн жилд энэхүү төлөвлөгөөгөө давуулан биелүүлж олон улсын хэд хэдэн байгууллагатай техник, эдийн засгийн өргөн хүрээнд хамтран ажилласан байна.

“Нээлттэй нийгэм форум” ТББ, ХЗТТ-ийн хамтарсан ажлын хэсэг байгуулан төвийн нийт улсын өмгөөлөгчдөд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд цаашид ч хамтран ажиллахаар тохиролцсон байна.

Эдгээрээс гадна БНХАУ-ын Хууль зүйн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв, Олон улсын эрх зүйн сан /ILF/, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/, Канад улсын Онтарио мужийн Хууль зүйн туслалцааны төв, Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд зэрэг олон улсын болон гадаадын дипломат албан тушаалтнуудтай холбогдож цаашид хүний эрхийг хангах, хууль зүйн туслалцааны үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тохиролцоо хийсэн байна.

“Хууль зүйн туслалцааны төвийн захирал В.Оюумаа, 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-ын Хууль зүйн туслалцааны төвийн Дэд захирал Шиа Хуйтай хоёр байгууллагын хамтран ажиллах үйл ажиллагаа, ирээдүйд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний талаар цахим уулзалт зохион байгуулсан.

Германы Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр 2023 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэлх хугацаанд Хууль зүйн туслалцааны төвийн албан хаагчид, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Мандал суманд албан томилолтоор ажиллав. Ханнс

Зайделийн сангийн санхүүжилтээр Хууль зүйн туслалцааны төвийн танилцуулга брошурыг 2000 ширхэгийг хэвлэж, олон нийтэд түгээв.

2023 оны 11 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Энэтхэгийн засгийн газрын дэмжлэгтэйгээр олон улсын эрх зүйн сан /ILF/, НҮБ-ийн хөгжлийн агентлаг /UNDF/, НҮБ-ийн хүүхдийн сан /UNICEF/, Энэтхэгийн хууль зүйн туслалцааны төв /NALSA/-аас хамтран

зохион байгуулсан “Өмнөд бүсэд шударга ёсыг бэхжүүлэх нь” хууль зүйн туслалцаа авах эрхийн тухай анхны бүс нутгийн чуулга уулзалтад Төвийн албан хаагч оролцож “Эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай НҮБ-ын зарчим, зөвлөмжид заасан “төр нь прокурортой дүйцэхүйц шударга болон пропорциональ санхүүжилтийг хангаж ажиллана...” гэх зохицуулалтыг хуулийн шинэчилсэн найруулгад оруулж, УИХ-аар хэрхэн батлуулсан тухай” сэдэвт илтгэлийг хэлэлцүүлсэн.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар хэрэгжүүлж буй “Хууль зүйн салбарын хууль зүй, мэдээллийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх” төслөөр Хууль зүй, туслалцааны төвийн мэдээллийн нэгдсэн сан буюу улсын өмгөөлөгч нарын хэргийн хөдөлгөөний бүртгэлийн программ, веб хуудас хийх болон тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдэхээр болсон бөгөөд 2023 оны 7 дугаар сарын 24-ны өдөр төслийн эхлэлийн уулзалтыг хийсэн. Төсөл эхэлснээс хойш 36 удаагийн уулзалтаар төвийн ажлын хэсэг, холбогдох судалгаа, мэдээлэл, саналыг бүрэн хийж өгсөн бөгөөд систем хөгжүүлэлтийн шатанд явж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд нийт албан хаагчдад “Хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Азийн сантай хамтран тус сангаас хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд “Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт” сургалтыг нийт албан хаагчдад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах нь” сэдэвт сургалтыг нийт албан хаагчдад 2023 оны 05 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр “Сэтгэцийн гэмтэл, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч даван туулагчид ээлтэй үйлчилгээ, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад төвийн 32 албан хаагчийг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хамруулсан.



Дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр: Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 24 дүгээр зүйлд Монголын Хуульчдын холбоо нь улсын өмгөөлөгчийг хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлж, хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах

бөгөөд улсын өмгөөлөгчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн бол шийдвэрийг ХЗТТ-д хүргүүлэх байдлаар хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллана гэж заажээ.

ХЗТТ нь дотоод хамтын ажиллагааны хүрээнд нийт улсын өмгөөлөгчдийг хуульчийн багц цагийг хангах 4 кредитийн сургалтад бүрэн хамруулсан байна.

Монголын Хуульчдын Холбоотой улсын өмгөөлөгчийн кредитын татвар болон мэдээлэл тайлан солилцон ажиллаж байна. Хуульчдын холбоо нь ХЗТТ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан эсвэл улсын өмгөөлөгчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн талаар мэдэгдсэн тохиолдол энэхүү судалгааны явцад илрээгүй байна.

Харин Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлд Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, тус холбооноос улсын өмгөөлөгчид үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын тогтолцоог бий болгох, эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг ХЗТТ-ийн захирал, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч хамтран батлах бөгөөд улсын өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, дуусгавар болгосон, түдгэлзүүлсэн бол шийдвэрийг ХЗТТ-д мэдэгдэх байдлаар хамтран ажиллана гэж заасан байна. Эдгээрээс “Хувийн өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журам”-ы төслийг ХЗТТ-өөс боловсруулж Монголын Өмгөөлөгчдийн холбоонд хүргүүлсэн бөгөөд өмгөөлөгчид үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын тогтолцоог бий болгох, улсын өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, дуусгавар болгосон, түдгэлзүүлсэн талаар мэдээлэл хүргүүлж хамтран ажилласан тохиолдол судалгааны явцад илрээгүй байна. МӨХ-ны хамтын ажиллагааны хүрээнд улсын өмгөөлөгчдийн 2023 оны гишүүний татварыг чөлөөлсөн.

АШУҮИС-ын эмгэг судлал, шүүх эмнэлгийн тэнхимийн багш, мэргэжлийн сэтгэл зүйч эмч нартай хамтран Төвийн нийт албан хаагчдад “Гэмт хэргийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэдтэй харилцахад анхаарах зүйлс” сэдвээр захиалгат сургалт зохион байгуулсан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын өгсөн чиглэлийн дагуу нийт албан хаагчдад шахмал түлш түлэх арга ажиллагаа болон угаартахаас урьдчилан сэргийлэх тухай холбогдох мэдээлэл, танилцуулгыг цахимаар, дотоод сүлжээгээр хүргэж, олон нийтэд төвийн www.lac.gov.mn цахим хуудсаар мэдээлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн зэргийг дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хийсэн ажил гэж үзэж байна. Мөн хамтын ажиллагаа бүхий байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулсан нь эерэг үр дүнтэй болсон гэж дүгнэж байна. Тухайлбал,

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах монголын нийгэмлэг төрийн бус байгууллага хамтран 2023.01.27-ны өдөр зохион байгуулсан “Мансууруулах бодисын хамааралтай хүнд нийгэм, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх нь: Япон улсын сайн туршлага” сэдэвт сургалт.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Эрх зүйн хэлтэс, Стандарт, хэмжил зүйн газраас 2023.03.02-ны өдөр зохион байгуулсан “Стандартчилал, хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлого”, “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн төслийг танилцуулах, санал солилцох зорилго бүхий хэлэлцүүлэг.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2023.03.10-ны өдөр зохион байгуулсан “Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд түншлэлийн тухай ойлголтыг таниулах нь” сургалт.

МОУА-аас 2023.03.15-16-ны өдрүүдэд зохион байгуулсан “Арбитрч бэлтгэх сургалт”
Хууль Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газраас 2023 оны 03 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсан “Гэмт хэргийн хохирогчийн судалгаа ба гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллын сургалт”.

Нийслэлийн онцгой байдлын газрын Сургалт арга зүйн төвтэй хамтран 2023.04.13-ны өдөр зохион байгуулсан “Аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт анхан шатны сургалт.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газартай хамтран 2023.04-10 саруудад “Монгол хэлний дохионы хэлмэрчийн сургалт”-д 4 албан хаагчийг хамруулж, “Дохионы хэлний анхан шатны сургалт”.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2023.04.17-ны өдөр “Төрийн сангийн удирдлагын цахим системийн сургалт”.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын урилгаар хүрэлцэн ирж БНСУ-ын Хууль тогтоомжийн сайд асан Ли Сог Ён-ий илтгэсэн 2023.05.12-ны өдрийн “БНСУ болон Монгол Улсын авлигатай тэмцэх бодлого, тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, туршлага ба сургамж” сэдэвт лекц.

Монгол улсын засгийн газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан хамтран 2023.05.09-11-ний өдрүүдэд зохион байгуулсан “Хүүхдийг хамгаалах ба улс хоорондын үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцын үүрэг” сэдэвт сургалтад 1 албан хаагч хамрагдсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 2023.07.09-10-ны өдрүүдэд зохион байгуулсан Монголын Эдийн засгийн чуулган.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 2023.08.29-ний өдөр зохион байгуулсан “Төрийн бүтээмж ба үнэлгээ, мониторинг” сэдэвт хэлэлцүүлэг.

Удирдлагын академиас 2023.09.05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан “Байгууллагын шийдвэр: Хууль хэрэглээ” сэдэвт сургалт.

УИХ-ын нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023.09.12-ны өдөр зохион байгуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх бодлого” сэдэвт хэлэлцүүлэг.

Удирдлагын академиас 2023.10.04-05-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сэдэвт 20 багц цагийн сургалт.

Хүний Эрхийн Комисс 2023.10.10-ны өдөр зохион байгуулсан "Хүний хувийн мэдээлэл хамгаалах нь" сургагч багш бэлтгэх сургалт.

Монголын хуульчдын холбооноос 2023.10.23-ны өдөр зохион байгуулсан “Хүүхдийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөө” сэдэвт хэлэлцүүлэг.

Залуу судлаачдыг дэмжих сан төрийн бус байгууллага 2023 оны 10 дугаар сарын .24-ний өдөр зохион байгуулсан "Үндсэн Хуулийн 2 дугаар бүлэгт орсон хүний эрхийн нэр томъёонд тодорхойлолт боловсруулах нь" хэлэлцүүлэг.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2023.10. 31-ний өдөр зохион байгуулсан "Хүний Эрхийн боловсролын арга зүй" симпозиум.

Монгол Улсын Хүний Эрхийн комисс 2023.12.08-ны өдөр зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Хүний Эрхийн Үндэсний Форум-2023" хэлэлцүүлэг.


Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүний эрх үндэсний эрхийн комисстой хамтран 2023 оны 12 джгаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц” сэдэвт сургалт.

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх олон талт хамтын ажиллагаа үндэсний чуулганд “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлж буй өмгөөлөл, хууль зүйн туслалцаа, түүнд тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хамрах хүрээ, төвийн үйл ажиллагааны талаар танилцуулан ажилласан.

Монголын хуульчдын холбооны Сургалтын хороотой хамтран “Хууль зүйн туслалцааны төвийн албан хаагч, улсын өмгөөлөгчдийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, албан хаагчдыг хамруулсан нь сайшаалтай юм.

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа нь үндсэндээ төрийн, төрийн бус, олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаатай нягт холбоотой бөгөөд гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх нь байгууллагын нэн тэргүүнд ач холбогдол өгөх чухал ажил болох нь тодорхой байна. Энэ чиглэлээр ХЗТТ төрөл бүрийн үйл ажиллагааг санаачлан ялангуяа цахим хөгжил буюу байгууллагын үйл ажиллагаагаа цахимжуулах болон албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх хүрээнд хамтын ажиллагааг илүү сайн ашигласан нь ажиглагдаж байна.

Хамтын ажиллагаагаа цаашид өргөжүүлэн хөгжүүлэхдээ ХЗТТ нь зорилтот бүлгүүдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг давхцалгүй, үр дүнтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэх, байгууллагын албан хаагчдад чиглэсэн ажлаас илүү гадагш буюу иргэд, хамтран ажиллагч байгууллагууд руу чиглэсэн ажлуудад илүү ач холбогдол өгөх хамтын ажиллагааг чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.



ГУРАВ. УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. Улсын өмгөөлөгчийн ажиллах орчин нөхцөл

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 16 дугаар зүйлийн 16.1-т Улсын өмгөөлөгч нь хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж байгаа, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй, хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа албан хаагч байна гэж хуульчилсан байна.

Улсын өмгөөлөгч нь төрийн албан хаагчид хамаарах бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно гэсэн суурь хэм хэмжээний хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 16 дугаар зүйлд заасан Улсын өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгааг эдэлнэ.

Аймаг Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлд, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулж өгсөн нь шинэ хуулийн нэг ололт юм.

Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-т Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Хууль зүйн туслалцааны төвийн 2023 онд боловсруулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, улсын өмгөөлөгч, үйлчлүүлэгч, хамтын ажиллагаатай байгууллагын төлөөллөөс асуулга судалгаа авч улсын өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгаанд зохих үнэлгээ хийсэн болно.





2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хууль зүйн туслалцааны төвийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулах зорилтын хүрээнд Орон нутаг дахь салбарын ажлын байрны асуудлыг шийдвэрлүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж гүйцэтгэл нь 100 хувьтай хэрэгжсэн гэжээ. Үүнд:



Төвийн ажлын алба нь Нийслэлийн засаг захиргааны 4-р байранд үйл ажиллагааг явуулж байгаад ажлын байр нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хуулийн этгээдэд шилжсэний улмаас ажлын байрыг суллаж өгөх нөхцөл байдал үүссэний улмаас Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, Хүрээ төвийн 1 давхарт нүүн ажиллаж байгаа бөгөөд ажлын байрны орчин нөхцөл сайжирсан.

Салбарын ажиллах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд аймаг, дүүргүүдийн Засаг дарга нараас дэмжлэг хүсэж, хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлж, утсаар болон биечлэн уулзалт хийж зохих арга хэмжээ авсан ба 7 салбарын ажиллах нөхцөл сайжирсан. Үүнд:

- Сонгинохайрхан дүүрэг дэх дүүргийн шинэ байрны 7 давхарт;
- Баянгол дүүрэг дэх салбар ажлын байргүй байсан бөгөөд дүүргийн ЗДТГ-ын байрны 1 давхарт 102 тоотод;
- Дархан-Уул аймаг дахь салбар аймгийн ЗДТГ-ын байрны 5 тоотод;
- Говь-Алтай аймаг дахь салбар Архивын байрны барилгад;
- Ховд аймаг дахь салбар аймгийн ЗДТГ-ын 1 давхар 101 тоотод;
- Орхон аймаг дахь салбар “Тэст” багийн шинэ барилгад;
- Баянзүрх дүүрэг дэх салбар нь ажлын байргүй байсан бөгөөд хуучин БЗД-ийн иргэний бүртгэлийн байранд 2 өрөө ажлын байртай болж, дүүргийн ЗДТГ-аас 3 ширхэг суурин компьютер, 1 ширхэг нөүтбүүк, ширээ, сандлыг хүлээлгэн өгсөн.



Судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгчийн 44.4 хувь нь материаллаг орчин нөхцөл тааруу гэж хариулсан байна. Өмнөх жилийн судалгааны дүнгээр 64.3 хувь нь ажиллах орчин нөхцөл тулгарч буй гол бэрхшээл гэж үзэж байсан бол энэ оны байдлаар 19.9 хувиар буурсан байна. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангах, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг улам сайжруулах ажлыг үргэлжлүүлбэл, аятай таатай ажиллах нөхцөл бүрдэх боломжтой байна. Хууль зүйн туслалцааны төвийн нийслэлийн болон орон нутгийн 30 салбар өөрийн ажлын байртай болж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

3.2. Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно гэж, мөн зүйлийн 2.4 дэх хэсэгт Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ гэж төрийн албан хаагчид цалин хөлс олгох хэм хэмжээг тусгасан байна.

Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал, тохирсон цалин хөлсний талаар холбогдох хууль тогтоомжийг судлан, Хууль зүйн туслалцааны төвийн 2023 оны гүйцэтгэлийн тайлан, улсын өмгөөлөгчөөс асуулгаар судалгаа хийж үнэлгээ хийсэн.

Төвийн 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Улсын өмгөөлөгчдийн цалин хөлс, урамшууллын тогтолцоо, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр дараахь ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэжээ. Тухайлбал, улсын өмгөөлөгчдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Төвийн албан хаагчийн ажлын үр дүнг шалгуурын дагуу үнэлж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсанаар улсын өмгөөлөгч дараах нийгмийн баталгаагаар хангагдах эрх зүйн орчин бүрдсэн. *Үүнд: өмгөөлөгчийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангагдах; жил бүр төрийн зардлаар эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах; хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд мөнгөн урамшууллыг олгох; Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасан гишүүний татвар, өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрөөс улсын өмгөөлөгчөөр ажиллах хугацаанд чөлөөлөгдөх г.м*

Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д зааснаар улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн албан тушаалын цалингийн хэмжээг прокурорын албан тушаалын цалинтай дүйцүүлсэн итгэлцүүрээр цалинжих эрх зүйн орчин бүрдүүлсэн талаар дараах эрх зүйн актыг боловсруулж, батлуулсан байна.

1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 486 дугаар тогтоолын хавсралтаар “Улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”-ийг баталж, 2023 оны 01 дүгээр сараас эхлэн улсын өмгөөлөгчийн цалин хөлсийг нэмэгдүүлэн олгож эхэлсэн.

2.Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Хууль зүйн туслалцааны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд “Улсын өмгөөлөгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн ба Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр тус журмыг баталсан.

3.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хамтарсан А/104, А/83, 88 тушаалаар “Улсын өмгөөлөгч болон улсын өмгөөлөгчийн туслахад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийг батлан тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2023.05.16-ны өдрийн А/19 дугаар тушаалаар ур чадвар үнэлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, улсын өмгөөлөгч болон, улсын өмгөөлөгчийн туслахын ур


чадварыг үнэлж, сар бүр 25 хувь хүртэлх ур чадварын нэмэгдлийг 2023 оны 6, 12 дугаар сард улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслахын ур чадварыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар үнэлж, нэмэгдлийг 2023 оны 7. 12 дугаар сард эхлэн олгосон.

4.Төрийн захиргааны албан хаагчдад өдрийн хоолны хөнгөлөлтөд 5000 төгрөг, нийтийн тээврийн угааны хөнгөлөлтөд 500 төгрөгийг сар бүр олгосон.

5.Мөн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2023 оны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулж, 2023 онд 3 албан хаагчид 600,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг, 2 албан хаагчид МӨХ-ны Их хуралд оролцох ирж, буцах унааны зардалд 150,800 төгрөгийг, 1 албан хаагчид Өмнөговь аймгийн ИТХ-аас хэрэгжүүлж буй “Нутгийн дэм” хөтөлбөрийн хүрээнд олгож буй урамшууллыг байгууллагын дансаар дамжуулан 2023 оны 9 дүгээр сараас эхлэн сар бүр 400,000 төгрөгийг олгосон байна.


6.Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 2023 онд 6 албан хаагчид жирэмсний болон амаржсаны амралт, 4 албан хаагчид хүүхэд асрах чөлөө, 4 албан хаагчид хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлага олгосон.

График 30. Улсын өмгөөлөгчийн ажлын ачааллын талаарх үнэлгээ




Улсын өмгөөлөгчдийн 42.6 хувь нь ажлын ачаалал ихтэй гэж, 57.4 хувь нь хэвийн ачаалалтай гэж хариулсан нь өмнө оноос 11.1 хувиар буурч, өссөн харьцаа нь эерэг үр дүн гарсан байна.

График 31. Долоо хоногт ажлын шаардлагаар илүү цагаар ажиллах шаардлага гардаг эсэх



Албан хаагчдын долоо хоногт ажлын шаардлагаар илүү цагаар ажиллах шаардлага гардаг эсэхэд 9 хувь нь 4 ба түүнээс дээш удаа, 43 хувь нь 2-3 удаа, 19 хувь нь 1 удаа, 28 хувь нь амралтын өдрүүдээр гэж хариулсан нь албан хаагчид ажлын ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна. Цаашид улсын өмгөөлөгчдийн ажлын цаг ашиглалт болон ажлын ачааллын судалгааг гүйцэтгэсний үндсэн дээр орон тоог зохист түвшинд хүргэх замаар ажлын ачааллын тэнцвэржүүлэх нь зүйтэй байна. Төв 2024 оны улсын төсөвт улсын өмгөөлөгч, албан хаагчийн орон тоог 25 нэмэгдүүлэхээр шийдвэрлүүлсэн нь сайшаалтай.

График 29. Авч буй цалиндаа сэтгэл хангалуун байдаг эсэх




Төвийн албан хаагчид авч буй цалиндаа 37 хувь нь сэтгэл хангалуун, 55.6 хувь нь сэтгэл дундуур, 7.4 хувь нь хангалтгүй гэж хариулсан байна. Цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлээд 1 жилийн хугацаа болж байгаа энэ үед ийм хариулт гарч байгаа нь эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж дүгнэлт хийх нь илүү оновчтой юм.

3.3. Улсын өмгөөлөгчийн мэргэшүүлэх, чадавхижуулах сургалт

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.4-т хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах гэж хуульчилж, МХХ-ны Зөвлөлийн 2014 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам”-ын 6.1 дүгээр зүйлийн 1-т Хуульч жил бүр 4-өөс доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх бөгөөд 1-ээс багц цаг нь мэргэжлийн суурь сургалт, 3 багц цаг нь мэргэшүүлэх чиглэлийн сургалт байна гэж, Өмгөөллийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т Өмгөөлөгчийн шалгалт болон үргэлжилсэн сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий Мэргэшлийн хороо ... ажиллах гэж хуульчилж, МӨХ-ны Удирдах зөвлөлийн 2021 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Мэргэшлийн хорооны ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-т Мэргэшлийн хороо нь өмгөөлөгчийн шалгалт болон үргэлжилсэн сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий Өмгөөллийн холбооны бүтцийн байгууллага... мөн зүйлийн 3.3-т Өмгөөлөгчийн үргэлжилсэн сургалтын зорилго нь өмгөөлөгчийн мэргэшлийн мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдлыг шинжлэх ухааны орчин үеийн онол, үзэл баримтлал, эрх зүйн шинэтгэлийн хандлага, практик нийцүүлэн дээшлүүлж, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга хараат бусаар тууштай ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ гэж заажээ. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаанд хуульчийн мэргэжлийн болон өмгөөллийн үйл ажиллагааны зарчмаас гадна мэргэшсэн, тогтвортой байх гэсэн тусгай зарчмыг хуульчилсан нь улсын өмгөөлөгч нь нийгмийн эрэлт хэрэгцээнд үндэслэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд эрх зүйн салбараар болон сэтгэл зүйн суурь мэдлэг ойлголттой болох хэрэгцээ шаардлага үүсэж буйг тэмдэглэж байна. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор үйлчлүүлэгчийн хүрээ өргөсөн улсын өмгөөлөгчдөд салбар эрх зүйгээр мэргэших хэрэгцээ шаардлага үүссэн эсэх талаар болон цаашид зохион байгуулах хуульчийн үргэлжилсэн сургалтад өмгөөлөгчийн мэргэшин ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалтыг ямар хөтөлбөр боловсруулах талаар хийсэн судалгааны дүнг танилцуулж байна.

График 32. Улсын өмгөөлөгчийн мэргэшсэн салбар эрх зүй




Судалгаанд хамрагдсан улсын өмөөлөгчдийн 81.5 хувь нь эрүүгийн эрх зүй, 11.5 хувь нь иргэний эрх зүй, 1.9 хувь нь захиргааны эрх зүй гэж хариулсан байна. Энэ нь хууль

тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой байх бөгөөд бусад салбар эрх зүйгээр мэргэшүүлэх, тэнцвэржүүлэхэд анхаарах шаардлагатай.


Судалгаанд хамрагдсан нийт өмгөөлөгчдийн 85.4 хувь нь хуулийн хэрэгжилтийг хангахад бэлэн гэж хариулсан бол 14.6 хувь нь бэлэн бус буюу мэргэшүүлэх сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага буйгаа илэрхийлсэн байна.

График 33. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн үйлчилсэн хугацаанаас хойш иргэний болон захиргааны хэрэгт ажилласан эсэх



Судалгаанд хамрагдсан нийт өмгөөлөгчийн 45.3 хувь нь иргэний болон захиргааны хэрэг маргаанд өмгөөлөгчөөр ажилласан, 54.7 нь ажиллаагүй гэж хариулсан бол өмнөх оноос 25.3 хувиар өссөн байна. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн үйлчлэлийн хүрээ өргөсөж, иргэний болон захиргааны хэрэг маргаанд улсын өмгөөлөгчийн оролцоо нэмэгдсэн байгаа нь илэрхий байна.

График 34. Эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтанд хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх




Улсын өмгөөлөгчид эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтанд хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхэд 46.3 хувь маш их, 44.4 хувь нь их, 9.3 хувь дунд зэрэг гэж хариулсан байна.

Судалгаанд оролцсон нийт өмгөөлөгчдийн 90.7 хувь нь эрх зүйн салбараар мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага маш их болон их

гэж хариулжээ. Энэ нь өмнөх оноос 7.8 хувиар өссөн байна. Хууль зүйн туслалцааны төвөөс улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалтыг МХХ, МӨХ болон холбогдох бусад байгууллагатай хамтран 2023 оны 5 сард хуульчийн үргэлжилсэн сургалтын 4 багц цаг тооцох сургалтыг эрүү, иргэн, захиргааны эрх зүйн чиглэлээр зохион байгуулсан байна. Мөн англи хэлний болон бусад сургалтуудыг тогтмол зохион байгуулсан тайланд дэлгэрэнгүй тайлагнасан байна. Төвөөс дангаар болон хамтын ажиллагаа бүхий байгууллагуудтай хамтран зохион байгуулсан мэргэшүүлэх, чадавхижуулах, хувь хүний хөгжлийг дэмжих сургалтууд нь зорилтот сэдэв, агуулга бүхий байхаас гадна зорилтот албан хаагчдыг хамруулсан нь оновчтой, хэрэгцээт зөв зохион байгуулалт болсоныг онцлон тэмдэглэж байна.

График 35. Хууль зүйн туслалцааны төвөөс явуулдаг улсын өмгөөлөгчийг чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийн үнэлгээ



Хууль зүйн туслалцааны төвөөс явуулдаг улсын өмгөөлөгчийг чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийн үнэлгээг 30.8 хувь маш сайн, 63.5 хувь нь сайн, 5.8 хувь дунд зэрэг гэж хариулсан байна. Тус төвөөс явуулсан сургалтын чанар, үр өгөөж өндөр байгааг харуулж байна.

Хууль зүйн туслалцааны төвөөс хуульд заасан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан дээр дурдсан мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтын чанар, үр өгөөжийг нийт судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 94.3 хувь нь маш сайн, сайн, 5.8 хувь нь дунд, 0 хувь нь муу гэж үнэлсэнээс дүгнэн үзвэл тухайн жилд зохион байгуулсан сургалтыг үр өгөөжтэй болжээ гэж дүгнэж болохоор байна. Өмнөх жилийн судалгааны дүнгээс 13.8 хувиар өссөн байгааг тэмдэглэж байна.

Цаашид мэргэшүүлэх сургалтын эрэлт хэрэгцээнд тулгуурлан, хамтын ажиллагаа бүхий байгууллагад сургалтын хөтөлбөр хамтран боловсруулах болон захиалгаар хөтөлбөр боловсруулах, МХХ-ны Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлэх зэрэг ажлыг хуулийн дагуу хамтын оролцооны зарчимд үндэслэн хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Бусад асуудлын хүрээнд 2023 онд төрийн дээд одон медаль хөдөлмөрийн хүндэт медалиар 6, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр 1, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хүндэт жуух бичгээр 11, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр 1, Монголын хуульчдын холбооны хүндэт медалиар 3 нийт 22 албан хаагчид шагнагдсан байна. 2023.12 29 өдрийг тохиолдуулан ерөнхийлөгчийн зарлигаар шагнагдах албан хаагчдын материалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн өргөн мэдүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүрэгтэй” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж, 2022 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс хэрэгжиж буй Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу төрөөс үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг Хууль зүйн туслалцааны төв нь улсын өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн албан хаагчид байгууллагын зөв соёл бүрдүүлэхэд анхаарч хичээнгүй ажиллаж байгаа байдал болон хийж буй ажилдаа сэтгэл хангалуун “аз жаргал”-тай хийдэг байдал ажиглагдаж байсныг онцлон тэмдэглэж байна. Байгууллагын удирдлага, албан хаагчид эерэг уур амьсгал, зөв соёл төлөвшүүлэхэд анхаарч ажиллаж байгаа нь тэдний үйл ажиллагаа, өөр хоорондын харилцаа хандлагаас шууд ажиглагдахуйц байгаа нь сайшаалтай байна.

Хамтын ажиллагаа бүхий байгууллагууд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу улсын өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлэх ажлын ачааллыг хэвийн гэж үзэж байна. Хууль зүйн туслалцааны тухай хууль болон ХЗТТ-ийн ажлын алба, улсын өмгөөлөгчийн чиг үүргийн талаарх мэдээллийг цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад улам дэлгэрэнгүй хүргэх нь цаашдын хамтын ажиллагаа болон хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө, үр дүнтэй юм. Ингэхдээ холбогдох байгууллагуудыг хамтран ажилладаг чиг үүргээр нь ангилах, мэдээлэл, сурталчилгааны ажлыг тэдэнд шууд чиглүүлэн хэрэгжүүлэх боломжтой.

Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын өмгөөлөгчийн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах нөхцөлийг сайжруулах, техник хэрэгслийг нэмэгдүүлэх шаардлагатай. ХЗТТ-ийн салбарын байрыг нэгдсэн стандарттай болгож, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай харилцах заалтыг хэрэгжүүлэх замаар ЗДТГ-аас дэмжиж ажиллах арга хэмжээг үргэлжлүүлэн ажиллавал, зохих үр дүнд хүрнэ гэж дүгнэж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангахад төрийн болон бусад байгууллагын хамтын ажиллагаа чухал бөгөөд улсын өмгөөлөгчийг мэргэшин ажиллахад чиглэсэн хуульчийн үргэлжилсэн сургалт болон чадавхижуулах сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалт зохион байгуулах, үйлчлүүлэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангахад хамтран дэмжлэг үзүүлэх ажлыг үе шаттай хамтран зохион байгуулах нь чухал байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгад эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх чиг үүргийг ХЗТТ-ийн туслалцаа үзүүлэх ажлын нэг төрөл байхаар хуульчилсан. Энэхүү ажлыг ХЗДХЯ-ны харьяа агентлаг,

байгууллагуудтай чиг үүргийн уялдаа холбоог хангаж, хамтатган зохион байгуулж хэвших шаардлагатай байна. Үүний зэрэгцээ мэдээлэл, сурталчилгааны ажлын хүртээмж, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт тогтоох нь тухайн үйл ажиллагааны үр дүнг улам бодитой болгох бас нэг үзүүлэлт болно.

Судалгаанд хамрагдсан иргэн, үйлчлүүлэгч болон хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөллөөс тухайн жилийн ХЗТТ-ийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчийн үйлчилгээг үнэлүүлэхэд нийт 37 үзүүлэлтийн дунджаар 94.6 хувьтай үнэлэгдэж байна.

№	Үнэлгээ	Хувь /1-100%/	Оноо/1-5/
1	Иргэд, үйлчлүүлэгчдийн үнэлгээ	96.5	4.8
2	Хамтын ажиллагаа бүхий байгууллагын үнэлгээ	88.6	4.4
3	Төвийн улсын өмгөөлөгч, албан хаагчдын үнэлгээ	98.6	4.9
4	Дундаж	94.6	4.7

Хууль зүйн туслалцааны төв нь өмнөх 2022 онд гүйцэтгүүлсэн хэрэглэгчийн үнэлгээний зөвлөмжийн дагуу Хуулийн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан байгууллагынхаа бүтэц орон тоог шинээр батлах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах ажлыг төлөвлөн холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэн 2023 оны эхний улирлаас эхлэн хуулийн биелэлтийг бүрэн ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Гэвч өмнөх оны зөвлөмжүүдээс цагдан хорих ангид буй сэжигтэн, яллагдагчтай улсын өмгөөлөгч очиж уулзах давтамжийг стандартчилах, академик судалгаа, шинжилгээний үйл ажиллагаанд гадаад, дотоод хамтын ажиллагааг чиглүүлэх гэсэн хоёр зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь ажиглагдлаа. Цаашид хэрэглэгчийн үнэлгээний судалгаанаас гарсан зөвлөмжүүдийг боломжит байдлаар хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд тулгуурлан ХЗТТ-ийн хамтын ажиллагаа, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн дараахь зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1.ХЗТТ-ийн бүтэц, орон тооны дагуу шаардлагатай /салбаргүй/ орон нутагт салбарыг шинээр байгуулах, улсын өмгөөлөгчийн ажлын ачааллыг харгалзан салбарын улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэх;

2.Улсын өмгөөлөгчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэн техник хэрэгсэлийн хангамжийг сайжруулахад анхаарах;

3.Хамтын ажиллагаа бүхий байгууллагын ажилтан, албан хаагчдад ХЗТТ-ийн чиг үүрэг, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл, сурталчилгаа, танилцуулга хийх;

4.ХЗТТ-ийн хууль зүйн туслалцаа үзүүлж буй байдал, үйлчилгээний талаарх мэдээлэл сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээх, тодорхой сэдэв, уриан дор үе шаттай зохион байгуулах:

5.Төвийн программ хангамж, системийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн танилцуулга сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулах:

6.Улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалтыг зорилтот төлөвлөгөөний дагуу жилд 2-с доошгүй удаа зохион байгуулах, хувь хүний хөгжлийг дэмжих сургалтыг тогтмол /бүх албан хаагчид болон хэсэгчлэн, бүсчилэн, салбараар/ зохион байгуулах.

-oOo-

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Үндсэн хууль
2. НҮБ-ын “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”
3. Төрийн албаны хууль
4. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)
5. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)
6. Өмгөөллийн тухай хууль
7. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
8. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг
9. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
10. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
11. Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”
12. МХХ-ны Зөвлөлийн 2014 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам”
13. ХЗТТ-ийн 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

